


БАТЛАВ.  
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

БУСАД УЛСААС ИРҮҮЛСЭН АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВЧ ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-14		
Баталсан огноо:	2025 он- 12 сар- 07 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр	Огноо	Гарын үсэг
	Х. Нарангун	2025.12.06	
Боловсруулсан:	Албан тушаал, нэр	Огноо	Гарын үсэг
	Р. Ганхуяг	2025.12.06	

### Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025. 11.30	
2					
3					

### Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

### **1.1. Журмын зорилго**

Энэ журмын зорилго нь бусад Улсаас ирүүлсэн аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авах, бүртгэх, судлах, хэрэгжилтийн явцыг хянах, санал гаргасан Улсад тогтоосон хугацаанд хариу хүргүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### **1.2. Хамрах хүрээ**

Энэ журмыг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанд ирүүлсэн агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил, зөрчилтэй холбоотой аюулгүй байдлын зөвлөмжид дагаж мөрдөнө.

### **1.3. Үндсэн зарчим**

Аюулгүй байдлын зөвлөмжийг шийдвэрлэхдээ дараах зарчмыг баримтална:

- 1.3.1. хугацаанд нь хүлээн авч бүртгэх;
- 1.3.2. бодитойгоор судалж шийдвэрлэх;
- 1.3.3. хэрэгжилтийн явцыг тасралтгүй хянах;
- 1.3.4. санал гаргасан Улсад хугацаанд нь албан ёсоор хариу хүргүүлэх;
- 1.3.5. шийдвэр, хэрэгжилтийн нотлох баримтыг бүрэн хадгалах;
- 1.3.6. аюулгүй ажиллагааг сайжруулах, урьдчилан сэргийлэхэд чиглүүлэх.

## **Хоёр. Нэр томьёо**

### **2.1. Аюулгүй байдлын зөвлөмж**

Осол, ноцтой зөрчил, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан зөвлөмж.

### **2.2. Санал гаргасан Улс**

Аюулгүй байдлын зөвлөмжийг ирүүлсэн Улс.

### **2.3. Хариуцсан нэгж**

Аюулгүй байдлын зөвлөмжийг судлах, хэрэгжилтийг зохион байгуулах, явцыг хянах, тайлагнах үүрэг бүхий Захиргаа судалгааны тасаг.

### **Гурав. Эрх, үүрэг**

#### **3.1. Бүртгэл, судалгааны мэргэжилтэн нь:**

- 3.1.1. ирсэн аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авч бүртгэх;
- 3.1.2. холбогдох нэгжид шилжүүлэх;
- 3.1.3. хэрэгжилтийн явцыг хянах;
- 3.1.4. санал гаргасан Улсад албан хариу хүргүүлэх;
- 3.1.5. холбогдох баримт, мэдээллийг нэгтгэн хадгалах.

#### **3.2. Хариуцсан нэгж нь:**

- 3.2.1. аюулгүй байдлын зөвлөмжийг судалж дүгнэлт гаргах;
- 3.2.2. авах арга хэмжээний санал боловсруулах;
- 3.2.3. хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл хүргүүлэх;
- 3.2.4. шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх.

### **Дөрөв. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авах, бүртгэх**

**4.1.** Бусад Улсаас ирүүлсэн аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан даруйд бүртгэлд оруулна.

**4.2.** Бүртгэлд дор хаяж дараах мэдээллийг тусгана:

- 4.2.1. зөвлөмжийн дугаар;
- 4.2.2. ирүүлсэн Улсын нэр;
- 4.2.3. ирсэн огноо;
- 4.2.4. зөвлөмжийн товч агуулга;
- 4.2.5. хариуцсан нэгж;
- 4.2.6. хариу хүргүүлэх хугацаа;
- 4.2.7. хэрэгжилтийн төлөв.

### **Тав. Судлах, шийдвэрлэх**

**5.1.** Ирсэн аюулгүй байдлын зөвлөмжийг хариуцсан нэгжид ажлын 3 өдрийн дотор шилжүүлнэ.

**5.2.** Хариуцсан нэгж аюулгүй байдлын зөвлөмжийг судалж дараах саналыг боловсруулна:

- 5.2.1. бүрэн хэрэгжүүлэх;
- 5.2.2. хэсэгчлэн хэрэгжүүлэх;
- 5.2.3. нэмэлт судалгаа хийх;
- 5.2.4. хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэх.

**5.3.** Аюулгүй байдлын зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд үндэслэл, тайлбарыг бичгээр боловсруулна.

### **Зургаа. Хэрэгжилтийн явцыг хянах**

**6.1.** Аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний явцыг [сар бүр/улирал тутам] хянана.

**6.2.** Хяналтын бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

- 6.2.1. авсан арга хэмжээ;
- 6.2.2. хэрэгжилтийн явц;
- 6.2.3. биелэлтийн нотлох баримт;
- 6.2.4. дуусах хугацаа;
- 6.2.5. хариуцсан албан тушаалтан.

**6.3.** Хэрэгжилт удааширсан, эсхүл нэмэлт шийдвэр шаардлагатай тохиолдолд удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.

### **Долоо. Санал гаргасан Улсад хариу хүргүүлэх**

**7.1.** Санал гаргасан Улсад аюулгүй байдлын зөвлөмжийн талаар 90 хоногийн дотор албан ёсны хариу хүргүүлнэ.

**7.2.** Албан хариунд дараахын аль нэгийг тусгана:

- 7.2.1. авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- 7.2.2. авч үзэж байгаа арга хэмжээ;
- 7.2.3. арга хэмжээ авахгүй байгаа шалтгаан.

**7.3.** Хэрэв арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаагүй бол хэрэгжилтийн явцын мэдээлэл болон цаашдын төлөвлөгөөг хариунд тусгана.

БУСАД УЛСААС ИРҮҮЛСЭН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖИЙГ

ХҮЛЭЭН АВЧ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

### **Найм. Баримтжуулалт, хадгалалт**

**8.1.** Ирсэн аюулгүй байдлын зөвлөмж, дотоод судалгаа, шийдвэр, албан хариу, хэрэгжилтийн нотлох баримтыг бүрэн бүрдүүлж хадгална.

**8.2.** Бүртгэл, албан бичиг, тайлан болон бусад холбогдох баримт материалыг хадгална.

### **Ес. Хяналт**

**9.1.** Энэхүү журмын хэрэгжилтэд ахлах шинжлэн шалгагч хяналт тавина.

**9.2.** Журмын хэрэгжилтийн байдлыг шаардлагатай тохиолдолд дотоод үнэлгээ, шалгалтад хамруулна.